



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 07 сарын 09 өдөр

Дугаар А/042

Булган сум

Үндэсний сурын харвааны цол олгох тухай

Монгол Улсын Үндэсний их баяр наадмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тулгар төрийн 2232, Их Монгол Улс байгуулагдсаны 817, Үндэсний эрх чөлөө тусгаар тогтнолоо сэргээн мандуулсны 112, Ардын хувьсгалын 102, Булган аймаг байгуулагдсаны 85 жилийн ойн их баяр наадмын Үндэсний сурын харваанд түрүүлсэн Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын уугуул "Шадар ван цэгц" клубын тамирчин, спортын мастер, аймгийн гарамгай харваач Чойжилжав овогтой Дагвадорж, Булган аймгийн Хишиг-Өндөр сумын уугуул "Хангарьд" спорт хорооны тамирчин, сумын мэргэн Ургамалсайхан овогтой Ууган-Эрдэнэд "Аймгийн мэргэн" цол, Сүхбаатар аймгийн Мөнххаан сумын уугуул "Нэгүн" клубын тамирчин, аймгийн гоц харваач, спортын мастер Сүхбаатар овогтой Батбаярт "Аймгийн гарамгай харваач", Баянхонгор аймгийн Баянхонгор сумын уугуул "мэргэн сум" клубын тамирчин, спортын мастер Батбаяр овогтой Доржванданд "Аймгийн гоц харваач" цол, Хөвсгөл аймгийн Төмөрбулаг сумын уугуул сумын мэргэн Жамъяндорж овогтой Сувд-Эрдэнэд "Аймгийн онц харваач" цол тус тус олгосугай.

2.Шинээр цол авсан харваачдад цолны үнэмлэх олгохыг баяр наадмын Үндэсний сурын харвааны салбар хороо (Ч.Энхбаяр)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ